

МОНГОЛЫН АРХЕОЛОГЧДЫН ХОЛБООНЫ ДҮРЭМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь “Монголын Археологчдын Холбоо” ТББ (цаашид “МАХ” гэх)-ны үйл ажиллагааны үндсэн зорилго, чиглэл, зохион байгуулалтын бүтэц, хяналтын тогтолцоо, удирдлага, санхүүжилт, өөрчлөх болон татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. МАХ нь Монголын археологич эрдэмтэн судлаачдын санаачлагаар үүсгэн байгуулагдсан, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагад бүртгэгдсэн, гишүүдийнхээ нийтлэг эрх ашгийг илэрхийлэх, археологийн шинжлэх ухааныг хөгжүүлэх үндсэн зорилго бүхий нийгэмд үйлчилдэг, ашгийн төлөө бус төрийн бус байгууллага мөн.

1.3. Шинжлэх ухааны өргөн мэдлэгтэй, мэргэжлийн өндөр ур чадвартай, ёс зүйтэй, эв эетэй гишүүд нь холбооны үнэт зүйл мөн.

1.4. МАХ нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн Хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү дүрмийг мөрдлөг болгоно.

1.5. МАХ-ны үйл ажиллагаа улс төрийн болон шашны үйл ажиллагаанаас ангид байх бөгөөд аливаа хөндлөнгийн иргэн, хуулийн этгээдээс хараат бус байна.

1.6. Холбооны оноосон нэрийг монголоор “Монголын Археологичдын Холбоо”, англиар “Association of Mongolian Archaeologists” гэнэ. Оноосон нэрийг Монголоор “МАХ”, Англиар “АМА” гэж товчилно.

1.7. МАХ нь өөрийн туг далбаа, тамга тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, харилцах данстай байна.

1.8. МАХ нь сурталчилгааны логотой байна.

1.9. МАХ-ны албан ёсны хаяг, Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Маргад төв, 201 тоотод байрлана. Утас: 976-77077066, цахим хуудас www.archaeology.mn

1.10. МАХ-г 2007 оны 03 дугаар сарын 15-ны өдөр үүсгэн байгуулагдсанд тооцно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

2.1. МАХ-ны эрхэм зорилго нь археологчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлж, хууль ёсны эрх ашгийг хамгаалах замаар археологийн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд оршино.

2.2. МАХ нь зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулна.

2.2.1. археологийн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд чиглэсэн төрийн бодлого төлөвлөлт, хууль тогтоомжийн төсөл боловсруулж, хэрэгжүүлэхэд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;

2.2.2. төрийн болон төрийн бус байгууллага, иргэнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр хууль тогтоомжоор хүлээн зөвшөөрөгдсөн ажил, арга хэмжээг гүйцэтгэх;

2.2.3. гишүүдийнхээ хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр хууль тогтоомжийн хүрээнд холбогдох арга хэмжээ авах;

2.2.4. Түүх, археологийн дурсгалыг гэмтээх, тонох, устгах болон соёлын өвийн хууль бус худалдаатай тэмцэх чиглэлээр хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;

2.2.5. эрдэм шинжилгээний хурал, уулзалт, сургалт, семинар зохион байгуулах;

2.2.6. гишүүдийг гадаад дотоодод давтан сургах, туршлага солилцуулахад дэмжлэг үзүүлэх;

2.2.7. гишүүдийг өөрийг нь болон судалгаа шинжилгээний ажлын үр дүнг гадаад дотоодод сурталчлах ажлыг зохион байгуулах;

2.2.8. гишүүдийг эрдмийн зэрэг, цол хамгаалахад нь бүх талын дэмжлэг үзүүлэх;

2.2.9. гишүүдийн салбарын хөгжилд оруулсан хувь нэмрийг урамшуулж, шагнах;

2.2.10. гишүүдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;

2.3. МАХ нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчмаас гадна дараах зарчмыг баримтлана.

2.3.1. ил тод нээлттэй байх;

2.3.2. тэгш хүртээмжтэй байх;

2.3.3. иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

2.3.4. итгэлцэл, хүндэтгэл, харилцан ойлголцлыг эрхэмлэх;

2.3.5. улс төрийн нам, шашны үйл ажиллагаанаас ангид байх.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ГИШҮҮНЧЛЭЛ

3.1. МАХ-ны дүрмийг хүлээн зөвшөөрч, сайн дурын үндсэн дээр гишүүнээр элсэхээр өргөдөл гаргасан гадаад дотоодын иргэнийг холбооны гишүүнээр элсүүлнэ.

3.2. Холбооны гишүүнээр элсэх өргөдөл гаргасан иргэнийг гишүүний жагсаалтад бүртгэж, үнэмлэх олгосноор гишүүний бүрэн эрх нь хэрэгжиж эхлэнэ.

3.3. МАХ-ны гишүүнчлэл нь гишүүн, хүндэт гишүүн гэсэн хэлбэртэй байна. Холбооны зорилго, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан иргэнийг бүх гишүүдийн хурлаас Хүндэт гишүүн болгож батламжилна.

3.4. Дараах иргэнийг холбооны гишүүнээр элсүүлэхгүй.

3.4.1. эрх зүйн чадамжгүй иргэн болон 18 насанд хүрээгүй иргэн;

3.4.2. холбооны дүрмийг зөрчиж, холбооноос хөөгдсөн иргэн;

3.4.3. ял шийтгэлтэй иргэн.

3.5. Холбооны гишүүний эрх, үүрэг.

3.5.1. гишүүний эрх.

а/ холбооны удирдлагын багт нэр дэвшиж сонгогдох;

б/ холбооноос зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд хамрагдах;

в/ холбооны үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр санал санаачлага гаргаж, шийдвэрлүүлэх;

г/ холбооны шагналд нэр дэвших;

д/ холбооны дүрэмд заасан дэмжлэг туслалцаа авах.

3.5.2. гишүүний үүрэг.

а/ холбооны зорилго, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд идэвхитэй оролцох;

б/ Бүх гишүүдийн хурлын шийдвэрийн дагуу гишүүн жилийн 60.000 төгрөг, дэмжигч гишүүн жилийн 30.000 төгрөгийн татварыг жил бүрийн 1-р сарын 25-ны дотор төлөх;

в/ холбооноос гаргасан аливаа шийдвэрийг дагаж мөрдөх;

г/ холбооны санхүүгийн бие даасан байдлыг бэхжүүлэх чиглэлээр хандив, тусламж цуглуулахад оролцох;

д/ холбооны удирдлагаас өгсөн үүрэг даалгаварыг цаг тухайд нь чанартай гүйцэтгэх.

3.6. Гишүүнийг дараах тохиолдолд холбооны гишүүнчлэлээс хасна.

- 3.6.1. гишүүн нас барсан;
- 3.6.2. өөрөө хүсэлтээ гаргасан;
- 3.6.3. гишүүний татвараа цаг хугацаанд нь төлөөгүй;
- 3.6.4. холбооны дүрмийг зөрчсөн талаар дүгнэлт гарсан.

3.7. Гишүүнийг дараах тохиолдолд холбооны гишүүнчлэлээс хөөнө.

3.7.1. дүрмийн бус аргаар холбооны зорилго, үйл ажиллагаанд харшлах үйл ажиллагаа явуулсан талаар дүгнэлт гарсан;

3.7.2. соёлын өвийн эсрэг болон авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдож, гэм буруутай болох нь шүүхийн байгууллагаар нотлогдсон.

3.8. гишүүнийг холбооны хөөх шийдвэрийг Бүх гишүүдийн хурлаас батламжлах хүртэлх хугацаанд гишүүний бүрэн эрхийг түтгэлзсэнд тооцож, холбооны аливаа үйл ажиллагаанд оролцуулахгүй.

3.9. Холбооны гишүүнийг энэхүү дүрэмд зааснаас бусад шалтгаанаар гишүүнчлэлээс хасах, хөөхийг хориглоно.

3.10. Холбооны гишүүнийг гишүүнчлэлээс хасагдсаж, хөөгдсөн тохиолдолд гишүүний татварт хураалгасан мөнгийг буцаан олгохгүй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ЭРХ БАРИХ ДЭЭД БАЙГУУЛЛАГА

4.1. Холбооны эрх барих дээд байгууллага нь Бүх гишүүдийн хурал байна.

4.2. Бүх гишүүдийн хурлыг жилд нэг удаа заавал зарлан хуралдуулна. Хурлын товыг Удирдах зөвлөлөөс тогтооно.

4.3. Удирдах зөвлөлийн гишүүдийн ердийн олонхийн саналаар эсхүл гишүүдийн ердийн олонхийн саналаар холбооны Бүх гишүүдийн хурлын зарлан хуралдуулж болно.

4.4. Бүх гишүүдийн хуралд гишүүдийн ердийн олонхи биечлэн ирж оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцно.

4.5. Бүх гишүүдийн хурлыг Хурлын тэргүүлэгчид удирдан явуулна. Хурлын тэргүүлэгчдийг гишүүдийн дундаас нэр дэвшүүлж, олонхийн саналаар сонгож батална.

4.6. Бүх гишүүдийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ.

4.6.1. холбооны дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах;

4.6.2. холбоог өөрчлөн байгуулах, татан буулгах;

- 4.6.3. холбооны урт, дунд хугацааны стратеги төлөвлөгөөг хэлэлцэж батлах;
- 4.6.4. холбооны төсвийг батлах;
- 4.6.5. холбооны тайланг хэлэлцэх;
- 4.6.6. холбооны Гүйцэтгэх захирал, нарийн бичгийн даргыг сонгож, батламжлах;
- 4.6.7. холбооны Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг сонгож батламжлах, өөрчлөх;
- 4.6.8. холбооны гишүүнийг хөөх шийдвэрийг батламжлах эсэх асуудлыг хэлэлцэх;
- 4.6.9. гишүүнчлэлийн татварын хувь хэмжээ болон Удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал, нарийн бичгийн даргын цалингийн хувь хэмжээг тогтоох;
- 4.6.10. холбооны үйл ажиллагаанд мөрдөх дүрэм журмыг батлах;
- 4.6.11. Удирдах зөвлөлийн шийдвэр, холбооны зорилго үйл ажиллагаанд харшлах талаар гишүүдээс гаргасан саналыг холбогдох хууль тогтоомж болон холбооны дүрэмд нийцэх эсэх асуудлаар дүгнэлт гаргаж, шаардлагатай бол шийдвэрийг хүчингүй болгох;
- 4.6.12. холбооны дээд шагналд нэр дэвшигчийг батламжлах.

4.7. Бүх гишүүдийн хурлаас холбооны Гүйцэтгэх захирал, нарийн бичгийн дарга, Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг сонгож, батламжлах үйл ажиллагааг ил санал хураалтаар шийдвэрлэнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ УДИРДАХ ЗӨВЛӨЛ

5.1. Бүх гишүүдийн хурлын чөлөөт цагт холбооны үйл ажиллагааг Удирдах зөвлөл хэрэгжүүлнэ.

5.2. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн 15 гишүүнтэй байна. Үүнд, Удирдах зөвлөлийн дарга, Гүйцэтгэх захирал, Нарийн бичгийн дарга болон 12 гишүүн багтана.

5.3. Удирдах зөвлөлийн даргыг зөвлөлийн гишүүдийн нууц санал хураалтаар сонгоно.

5.4. Удирдах зөвлөлийн сонгуулийг 3 жил тутам явуулна. Удирдах зөвлөлийн гишүүнийг 1 удаа улируулан сонгож болно.

5.5. Удирдах зөвлөлийн гишүүнийг Бүх гишүүдийн хурлаас нууц санал хураалтаар сонгоно.

5.6. Удирдах зөвлөлийн ээлжит хурлыг улирал бүр зохион байгуулна. Удирдах зөвлөлийн дарга, зөвлөлийн гишүүдийн олонхи болон Гүйцэтгэх захирлын саналаар ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно.

5.7. Удирдах зөвлөл хурлын дэгээ өөрөө тогтооно.

5.8. Удирдах зөвлөлийн дарга, гишүүн нь холбооны Гүйцэтгэх захирал, нарийн бичгийн даргаар хавсран ажиллахгүй.

5.9. Удирдах зөвлөлийн гишүүн өөрийн хүсэлтээр зөвлөлийн бүрэлдэхүүнээс огцрох, хүндэтгэн үзэх шалтгаанаар ажиллах боломжгүй болсон тохиолдолд Бүх гишүүдийн ээлжит болон ээлжит бус хурлаар нөхөн сонгууль явуулна.

5.10. Удирдах зөвлөл дараах чиг үүргийг гүйцэтгэнэ.

5.10.1. Бүх гишүүдийн хурлаар хэлэлцэх асуудлын төслийг боловсруулж, хэлэлцүүлэхэд бэлтгэх;

5.10.2. холбооны үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжилтэд хяналт тавих;

5.10.3. гишүүдийн татварын орлогын биелэлт болон түүний зарцуулалтад хяналт тавих;

5.10.4. Бүх гишүүдийн хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх;

5.10.5. холбооны гишүүнчлэлийн анкет, бүртгэлийн маягтын загварыг батлах;

5.10.6. холбооны дээд шагналд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах;

5.10.7. гишүүнийг холбооны гишүүнчлэлээс хасах, хөөх талаар санал гаргах;

5.10.8. холбооны Гүйцэтгэх захирал, нарийн бичгийн дарга нарын шийдвэр холбогдох хууль тогтоомж, холбооны дүрэмд харшилсан гэж үзвэл, шийдвэрийг түтгэлзүүлж, Бүх гишүүдийн хуралд оруулж шийдвэрлүүлэх;

5.10.9. холбооны зорилго, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай орон тооны дээд хязгаарыг батлах;

5.11. Удирдах зөвлөлийн гишүүдийн эрх, үүрэг.

5.11.1. Зөвлөлийн гишүүдийн эрх.

а/ холбооны үйл ажиллагааг удирдах чиг үүрэгтэй оролцох;

б/ гишүүний нийтлэг эрхийг эдлэнэ;

в/ зөвлөлийн хэлэлцэх асуудлын хүрээнд тодорхой санал боловсруулж, шийдвэрлүүлэх;

г/ холбооны дүрэм журамд заасан цалин, мөнгөн урамшуулал авах;

д/ өөрийн санаачлагаар зөвлөлийн дэргэдэх хорооны гишүүнээр ажиллах.

5.11.2. Зөвлөлийн гишүүний үүрэг.

а/ зөвлөлийн даргын үүрэг болгосноор тодорхой чиг үүрэгтэй байгуулсан ажлын хэсэгт орж ажиллах;

б/ Бүх гишүүдийн хурлаас тогтоосон жилийн 120.000 төгрөгийн татварыг төлөх;

в/ холбооны зорилго, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд манлайлан оролцох;

г/ зөвлөлийн хурлын шийдвэрийг дагаж мөрдөх;

д/ зөвлөлийн хуралд биечлэн оролцох, хурлын даргаас даалгасны дагуу зөвлөлийн хурлыг удирдах.

5.12. Удирдах зөвлөлийн даргын эрх, үүрэг.

5.12.1. Зөвлөлийн дарга дараах эрхийг эдлэнэ.

а/ Зөвлөлийн хурлыг удирдах;

б/ дүрмийн чиг үүргийн хүрээнд зөвлөлийг төлөөлөх;

в/ Зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хурлын товыг зарлан, хуралдуулах;

5.12.2. Зөвлөлийн дарга дараах үүрэг хүлээнэ.

а/ Зөвлөлийн гишүүдийн ажил үүргийг зөв оновчтой хуваарилж удирдах;

б/ Зөвлөлийн хурлын шийдвэрийг цаг тухайд нь албажуулах;

в/ Холбооны бүтцийн байгууллагад давхар ажил эрхлэхгүй байх.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

6.1. Холбооны өдөр тутмын үйл ажиллагааг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.

6.2. Гүйцэтгэх захирал дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

6.2.1. холбоонд шинээр гишүүн элсүүлэх;

6.2.2. Бүх гишүүдийн хурал болон Удирдах зөвлөлөөс гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх;

6.2.3. Холбооны санхүүгийн үйл ажиллагааг батлагдсан төсвийн хүрээнд захиран зарцуулж, сар улирал, жилийн тайланг гарган татварын байгууллагад хүргүүлж баталгаажуулах;

6.2.4. гишүүдтэй өдөр тутам харилцах, тэднийг Удирдах зөвлөлтэй холбож ажиллах;

6.2.5. холбооны үйл ажиллагааны талаар Удирдах зөвлөлийн хуралд танилцуулах;

6.2.6. Удирдах зөвлөлийн хуралд оруулж хэлэлцүүлэх асуудлын төслийг боловсруулж бэлтгэх;

6.2.7. батлагдсан орон тооны дээд хязгаарт багтаан холбооны гүйцэтгэх албан тушаалтныг томилж, чөлөөлөх;

6.2.8. Холбооны гүйцэтгэх албан тушаалтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулж дүгнэх;

6.2.9. Холбоог гадаад дотоодод төлөөлөх;

6.2.10. Удирдах зөвлөлөөс өгсөн заавар чиглэлийн дагуу гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх.

6.3. Гүйцэтгэх захирал нь тухайн жилд гүйцэтгэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулна.

6.4. Удирдах зөвлөлөөс Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 2 жил дараалан хангалтгүй үнэлэгдсэн бол чөлөөлөх асуудлыг Бүх гишүүдийн хуралд оруулж, хэлэлцүүлж болно.

6.5. Гүйцэтгэх захирлаар археологич мэргэжилтэй, эрдмийн зэрэг цолтой, 36 нас хүрсэн Монгол улсын иргэнийг сонгоно.

ДОЛДУГААР БҮЛЭГ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

7.1. Холбооны нарийн бичгийн даргыг Гүйцэтгэх захирлын санал болгосноор Бүх гишүүдийн хурлаас томилж, чөлөөлнө.

7.2. Холбооны нарийн бичгийн дарга нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

7.2.1. холбооны тамга тэмдгийг түших;

7.2.2. холбооны архив, албан хэрэг хөтлөлтийг хариуцах;

7.2.3. холбооны баримт бичгийг хадгалж, хамгаалах;

7.2.4. холбооны эд хөрөнгийг бүрэн бүтэн байдлыг хариуцах.

НАЙМДУГААР БҮЛЭГ ХҮНДЭТ ТЭРГҮҮН БА ХҮНДЭТ ГИШҮҮН

8.1. Монголын археологчдын холбоо нь Хүндэт тэргүүнтэй байна.

8.2. Хүндэт тэргүүн нь Удирдах зөвлөлийн зөвлөх эрхтэй гишүүн байна.

8.3. Холбооны бүх гишүүдийн хурлаас Хүндэт тэргүүнийг 5 жилийн хугацаатайгаар сонгоно.

8.4. Монголын археологчдын холбоо нь Хүндэт гишүүнтэй байна.

8.5. Хүндэт гишүүнд төрийн өндөр албан тушаалтан, төр нийгмийн нэрт зүтгэлтэн, урлаг соёлын алдартнууд, бизнесийн салбарын төлөөллийг өөрийнх нь саналыг харгалзан сонгож болно.

8.6. Хүндэт гишүүн нь холбооны үйл ажиллагааг дэмжиж дүрмийн 10.7.2 заалтын дагуу хандив өгч болно.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ХОРООД

9.1. Удирдах зөвлөл нь бүтэцдээ Ёс зүйн хороо, Хяналтын хороотой байна. Хорооны гишүүдийг Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнээс сонгож, томилно.

9.2. Хороо нь тус бүр 3 гишүүнтэй байх бөгөөд хороог гишүүдийн хамгийн ахмад нь даргална.

9.3. Хороод нь гишүүдийн үйл ажиллагаа холбогдох хууль тогтоомж, холбооны дүрэмд нийцэж байгаа эсэх асуудлаар дүгнэлт гаргаж, Удирдах зөвлөлийн хуралд танилцуулж, шийдвэрлүүлнэ.

9.4. Хороодын дүгнэлтэд хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.

9.5. Хороодын үйл ажиллагаанд мөрдөх журмыг Бүх гишүүдийн хурлаас батална.

9.6. Хороодын бүрэлдэхүүн Удирдах зөвлөлийн бүрэн эрхийн хугацаатай адил байна.

АРАВДУГААР БҮЛЭГ ЭД ХӨРӨНГӨ, САНХҮҮ

10.1. Холбоо нь хуулийн дагуу, шударгаар олж авсан өөрийн гэсэн биет болон биет бус өмчтэй байна.

10.2. Холбооны эд хөрөнгийг захиран зарцуулах эрхийг Бүх гишүүдийн хурал эдлэнэ.

10.3. Холбооны эд хөрөнгийг хувийн зорилгоор ашиглахыг хориглоно.

10.4. Холбооны хөрөнгийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу бүртгүүлэх ажлыг Гүйцэтгэх захирал хариуцна.

10.5. Гүйцэтгэх захирал Бүх гишүүдийн хурал болон Удирдах зөвлөлөөс өгсөн зөвшөөрлийн дагуу холбооны хөрөнгийг бусдад түрээслэх асуудлыг шийдвэрлэнэ. Түрээсийн орлогыг холбооны дансанд төвлөрүүлнэ.

10.6. Холбооны гишүүдийн дүрмээс гадуурх үйл ажиллагааны улмаас бусдад учруулсан хохирол, түүнээс үүсэх хариуцлагыг холбоо хариуцахгүй.

10.7. Холбооны орлого дараах эх үүсвэрээс бүрдэж болно. Үүнд:

10.7.1. гишүүдийн татвар;

10.7.2. гишүүд болон гадаад, дотоодын иргэд, байгууллагаас өгсөн хандив;

10.7.3. гадаад, дотоодын байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төслийн ажлын орлого;

10.7.4. Дүрмээр зөвшөөрөгдсөн үйл ажиллагаанаас олсон орлого;

10.7.5. байгууллагын бэлэгдэл бүхий бараа борлуулсаны орлого;

10.7.6. төсөл хэрэгжүүлэх зорилгоор Улсын төсвөөс олгосон хөрөнгө;

10.7.7. хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад орлого.

10.8. Холбооны санхүүгийн жил нь хуанлийн жилтэй давхцах бөгөөд жил бүрийн 1 дүгээр сарын 1-ээс эхэлж 12-р сарын 31-нд дуусна.

10.9. Холбооны санхүүгийн үйл ажиллагаанд Хяналтын хороо хөндлөнгийн аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулж болно.

10.10. Холбооны орлогоос ногдол ашиг хуваарилах, иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хөрөнгийн баталгаа гаргах, болон сонгууль нэр дэвшигч нам, эвсэл, иргэнд хандив өгөхийг хориглоно.

АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

11.1. Холбооны Бүх гишүүдийн хурлын шийдвэр, Удирдах зөвлөлийн хурлын шийдвэр, хороодын санал дүгнэлт, Гүйцэтгэх захирлын шийдвэр, бусадтай харилцсан албан бичгүүд, хурлын тэмлэглэлийг хадгалах, хуульд заасны дагуу архивын нэгж үүсгэн хадгалах асуудлыг холбооны нарийн бичгийн дарга хариуцна.

11.2. Холбооны Бүх гишүүдийн хурал, Удирдах зөвлөл, хороод, Гүйцэтгэх захирал нь энэхүү дүрэмд заасан бүрэн эрхийн хүрээнд шийдвэр гаргахад нөлөөлөхийг эрс цээрлэнэ.

11.3. Бүх гишүүдийн хурал болон Удирдах зөвлөлийн хурлын шийдвэр тогтоол хэлбэртэй байна.

11.4. Холбоо нь үйл ажиллагаагаа сурталчилах сэтгүүл, цахим хуудастай байна.

11.5. Холбоо нь жил бүр холбооны дээд шагналыг Бүх гишүүдийн хурлаас батламжилсан гишүүнд олгоно.

11.6. Холбооны дээд шагналд нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах, батламжлах журмыг Бүх гишүүдийн хурлаас батлана.

11.7. Холбооны дээд шагналыг Бүх гишүүдийн хурлын шийдвэрээр нэрэмжит болгож болно.

АРВАНХОЁРДУГААР БҮЛЭГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ

12.1. Бүх гишүүдийн хурлын шийдвэрээр шаардлагатай гэж үзвэл холбоо нь бусад байгууллагатай нэгдэн нийлэх, эсвэл хуваагдах, тусгаарлах замаар өөрчлөн байгуулагдаж болно.

12.2. Холбоог татан буулгах шийдвэрийг Бүх гишүүдийн хурал гаргана.

12.3. Татан буугдахад зохих төлбөр тооцоог хийсний дараа үлдсэн эд хөрөнгийг ижил төстэй төрийн бус байгууллагад шилжүүлэх, хэрэв тийм байгууллага байхгүй бол зорилгод нийцсэн үйл ажиллагаанд зарцуулна.

12.4. Татан буулгасан буюу өөрчлөн байгуулсан шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор холбогдох байгууллагуудад мэдэгдэнэ.

АРВАНГУРАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

13.1. Энэхүү шинэчлэн найруулсан дүрмийг холбооны 2019 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн Бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн баталсан бөгөөд 2019 оны 04 сарын 01-нээс эхлэн дагаж мөрдөнө.